



МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

Энхтайваны өргөн чөлөө 7а,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210  
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,  
Цахим шуудан: info@mfa.gov.mn,  
Цахим хуудас: www.mfa.gov.mn

23-01.09 № 08/113  
танай \_\_\_\_\_-ны № 03/235 -т

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН  
АЛБАНЫ ДАРГА Т.ЭНХБАЯР ТАНАА

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай  
хуулийн хүрээнд холбогдох маягтын дагуу  
2022 оны тайлан, мэдээг гаргаж хүргүүлэв.

Хавсралт 26 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ  
УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ



С.ЗОЛЖАРГАЛ

1172300206

## Хавсралт 1.

## Жендэрийн салбар зөвлөлийн гишүүдийн товч мэдээлэл

№	Салбар зөвлөлийн гишүүний овог нэр	Хүйс	Байгууллага, албан тушаал/ Мэргэжил	Улсад ажилласан жил	Төрийн албанд ажилласан жил	"Жендэр ба бодлого төлөвлөлт" анхан шатны сургагч багшийн гэрчилгээ авсан эсэх	Төрийн албаны удирдах албан тушаалтны жендэрийн цахим сургалтад хамрагдсан эсэх	Утасны дугаар	Цахим хаяг	Жендэрийн салбар зөвлөлийн чиг үүргийн хүрээнд хариуцаж буй үйл ажиллагааны чиглэл
1	С.Золжаргал	эр	ГХЯ-ны ТЗУГ-ын захирал	17	11	үгүй	үгүй	261819	Dep08@mfa.gov.mn	Салбар зөвлөлийн гишүүн
2	Ц.Навчаа	эм	ГХЯ-ны ОУГЭЗГ-ын Хүний эрхийн хэлтсийн дарга	16	15	үгүй	үгүй	262179	Dep09@mfa.gov.mn	Салбар зөвлөлийн гишүүн
3	Э.Жаргал	эм	ГХЯ-ны ОТХАГ-ын III нарийн бичгийн дарга	9	4	үгүй	үгүй	261933	Dep06@mfa.gov.mn	Салбар зөвлөлийн гишүүн
4	Ч.Сүхбаатар	эр	ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн	13	9	үгүй	үгүй	261954	Dep08@mfa.gov.mn	Салбар зөвлөлийн гишүүн
5	Г.Сувдсүрэн	эм	ТЗУГ-ын Зөвлөх	27	27	үгүй	үгүй	263159	Dep08@mfa.gov.mn	Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

## Хавсралт 2.

**Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар салбарт баримтлах бодлогын  
Хэрэгжилт, үр дүнгийн талаарх хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн тайлан**

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2021-12-31	Зорилтот түвшин 2023-12-31	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)	Салбар зөвлөлийн өөрийн үнэлгээ	ХШУДАГ-ЫН үнэлгээ
Бодлогын баримт бичиг: Гадаад харилцааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 13-ны А/41 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан Жендэрийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө								
Бодлогын зорилго 1. Дипломат албаны жендэрийн бодлогын баримт бичгийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулах								
Бодлогын зорилт 1: Дипломат албанд жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүйн орчин, бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох								
1.1.	Жендэрийн бодлогын баримт бичгийг яамны газар, нэгж, ДТГ-уудад хүргүүлэх, сурталчлах, хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжөөр хангах	0.5 сая төгрөг	Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгасан эх зүйн актын тоо	Дипломат албаны жендэрийн бодлогын баримт бичиг	Салбарын үйл ажиллагааны онцлогт тохирсон хүний нөөцийн бодлогын эрх зүйн орчин боловсронгуй болсон байх	Гадаад харилцааны сайдын 2020 онд баталсан Дипломат албаны Жендэрийн бодлогын баримт бичгийг яамны газар, нэгж, ДТГ-уудад хүргүүлэв. Мөн уг баримт бичгийн хоёрдугаар хавсралт болох Дипломат албаны жендэрийн бодлогыг /202-2025/ хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний	100%	100%

					<p>хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн ГХ-ны сайд Б.Батцэцэг 2022.12 дугаар сард Токио хотноо болсон Дэлхийн эмэгтэйчүүдийн 6 дугаар чуулганы Өндөр түвшний хэлэлцүүлэгт оролцож, жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, МУ-ын Дипломат албаны жендэрийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр жендэрийн ялгаварлан гадуурхалтыг эцэслэхэд оролцогч талуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, шийдвэр гаргах түвшинд оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаар танилцуулав.</p>		
--	--	--	--	--	---	--	--

1.2.	Дипломат албаны хүний нөөцийн бодлогын баримт бичгийг жендэрийн мэдрэмжтэй, тэгш боломжийг дэмжсэн заалтаар баяжуулах	0.2 сая төгрөг	Дипломат албаны мэргэшлийн тусгай шалгалтын журам, Албан тушаалын тодорхойлол тууд.	2020 онд яамны газар нэгжийн удирдлагын 30 хувь, ДТГ-ын тэргүүн нарын 13 хувь	ДТГ-ын хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах, тэргүүн нарын хувийг 5 хувиар ахиулах	ГХ-ны сайдын 2015.7.03-ны өдрийн А/63 тоот тушаалаар батлагдсан "Дипломат албаны хүний нөөцийн бодлого"-ын баримт бичигт "Хүний нөөцийн жендэрийн харьцаа зохих түвшинд, хуульд заасны дагуу 60:40-өөс хэтрэхгүй байх" гэж заасны дагуу ГХЯ болон ДТГ-ын хүйсийн тэнцвэртэй байдлыг жендэрийн мэдрэмжтэй, тэгш боломжоор хангаж ажиллав. Тухайлбал, 2021-2022 онд Монгол Улсаас БНИтали Улс, БНКуба Улс, Болгар Улс, БНСУ, АНУ-ын Чикаго хотод суугаа ЕКГ зэрэг ДТГ-уудын тэргүүнээр 5 эмэгтэй дипломатыг томиллов.	100%	100%
1.3.	Салбарын бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө,	0.5 сая төгрөг	Оролцооны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө	Салбарын үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш оролцоог	Гадаад харилцааны сайдын 2020.10.13-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар батлагдсан	100%	70%

	төсөв, тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн үзүүлэлтүүдийг тусгах		төсөв батлуулсан эсэх		дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломж бүрдэх	Дипломат албаны бодлогыг /2022-2025/ хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.		
1.4.	Жендэрийн талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төсөв боловсруулах сургалт зохион байгуулах	3 сая төгрөг	Сургалт, хэлэлцүүлгийн тоо 1-2, оролцогсдын тоо 150	Жендэрийн үнэлгээний тайлан, Дипломат албаны жендэрийн бодлогын баримт бичиг	Салбарын гүйцэтгэлийн төлөвлөгөө, жендэрийн мэдрэмжтэй төсөвтэй уялдах	2022 онд ЖҮХ-ноос зохион байгуулсан аянд ГХЯ-ыг төлөөлөн идэвхтэй оролцож, сурталчилгааны ажилд дэмжлэг үзүүлэв. ГХЯ болон ЖҮХ-ноос МУ-д үйл ажиллагаа явуулж буй ДТГ болон ОУБ-ын ТГ-ын төлөөллийг хамруулсан сургалтыг зохион байгуулав. -2022.11.16-ны өдөр ГХЯ-ны албан хаагчдад ЖҮХ-ны 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-	100%	100%

					<p>2031)"-г танилцуулах арга хэмжээг зохион байгуулав.</p> <p>-2022.12.01-ний өдөр Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан Жендэрийн тэгш байдлыг хангах салбар дундын хамтын ажиллагааны сургалтад яамны жендэрийн асуудал хариуцсан албан хаагч оролцов.</p> <p>-2022.12.04-ний өдөр ГХ-ны сайд Б.Батцэцэг Токио хотноо болсон Дэлхийн эмэгтэйчүүдийн 6 дугаар чуулганы Өндөр түвшний хэлэлцүүлэгт оролцож, жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, МУ-ын Дипломат албаны жендэрийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр жендэрийн ялгаварлан гадуурхалтыг</p>		
--	--	--	--	--	---	--	--

						эцэслэхэд оролцогч талуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, шийдвэр гаргах түвшинд оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаар танилцуулав.		
1.5.	Ажиллагсдын ар гэр- ажлын тэнцвэртэй байдлыг хангах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах	1 сая төгрөг	Бага насны хүүхэдтэй албан хаагчдын тоо 31	Жендэрийн үнэлгээний тайлан, Дипломат албаны жендэрийн бодлогын баримт бичиг	Өрх толгойлсон, олон хүүхэдтэй, бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүдэд тодорхой чөлөө олгох, илүү цагаар ажиллуулахгүй байх талаар Яам болон ДТГ-ын Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулсан байх	ГХЯ-ны ТНБД-ын 2020 оны А/34 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, цар тахлын нөхцөл байдлын үед албан хаагчдын эрүүл мэнд, гэр ажлын тэнцвэрт байдлыг хангаж, шаардлагатай тохиолдолд цахимаар ажиллуулах арга хэмжээг авч ажиллав. Мөн Дипломат албаны тухай хуулийн 23.1-д ДТГ-т ажиллагсадын эхнэр буюу нөхрийг тухайн төлөөлөгчийн газрын ажлын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн	100%	100%

						үйлчилгээ, техникийн ажилд гэрээний үндсэн дээр ажиллуулах, 23.2-т ДТГ-т ажиллагсадын эхнэр буюу нөхөр тодорхой ажил эрхлээгүй тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийг төрийн албан хаагчийн үндсэн цалингийн дундаж хэмжээгээр бодож төр хариуцна гэж заасны дагуу МУ-аас гадаад улсад суугаа ДТГ-уудад ажиллаж буй албан хаагчдын гэр бүлийг тухайн ДТГ-т ажлын байраар ханган ажиллаж байна.		
1.6.	Жендэрийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангахад жендэрийн мэдрэмжтэй төсөв боловсруулах	-	Хилийн чанад дахь ДТГ-т ажиллаж байхдаа хүүхэд төрүүлсэн албан хаагчид жирэмсний болон	Жендэрийн үнэлгээний тайлан, Дипломат албаны жендэрийн бодлогын баримт бичиг	Жирэмсний болон амаржсаны амралт эдлүүлэх, хүүхэд эсэн мэнд бойжих боломж, тогтолцоо бий болно.	ГХ-ны сайд 2015.5.12-ны өдрийн А/47 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж буй "ГХЯ-ны төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-т жирэмсний болон амарсаны дараах амралттай, нярай	100%	90%

			амаржсаны тэтгэмжийг албан тушаалын цалин, адилтгах албан тушаалын цалингийн зөрүүгээр тооцож олгосон үзүүлэлт			хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд ажлын байрыг хадаглах, урьд ажилласан байсаан түвшнээс бууруулахгүй байх, эхнэр нь амаржсан үед ажлын 10 хоногийн цалимтай амралт олгох, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх, ажилласан жил, ажлын үр дүн, ур чадварыг нь харгалзан шагнаж урамшуулах, албан тушаал дэвшүүлэх, хүйсээс үл хамааран хуульд заасан нийгмийн баталгаагаар хангах тухай заасан нь хүйсийн тэгш байдлыг хангах нэг нөхцөл болсон.		
1.7.	ДТГ-г ажиллаж буй албан хаагчдын эрүүл мэндийн нэгдсэн стандарт,	11,000 сая төгрөг	Эрүүл мэндийн даатгалын асуудлыг шийдвэрлэх зохицуулалт	Дипломат албаны жендэрийн бодлогын баримт бичиг	Эрүүл мэндийн хүртээмжтэй үйлчилгээ авах боломж бүрдүүлэх	Дипломат албаны тухай хуулийн 18.1.3-д суугаа орны эрүүл мэндийн даатгалд хамруулах гэсэн заалтын хүрээнд 2022 онд эрүүл мэндийн	100%	100%

	даатгалд хамруулах		ын механизм бий болох			даатгалд 11 тэрбум төгрөг төсөвлөсөн бөгөөд МУ-аас хилийн чанадад суугаа ДТГ-ууд хамрагдсан.		
Бодлогын 1 зорилго, 1 зорилтын хүрээнд 7 арга хэмжээнд 11,005.20 сая төгрөг төсөвлөж, төсвийн зарцуулалт 100 хувь, үйл ажиллагааны хэрэгжилт 97.1 хувьтай байна.								

### Хавсралт 3

#### Төрийн захиргааны төв, түүний харъяа агентлагт ажиллаж буй албан хаагчдын 2022 оны хүйсийн тэнцвэрт байдлын жилийн мэдээ

Тайлбар:Төрийн захиргааны төв байгууллага нь хавсралт 3-ын Маягт 1а, 1б, 1в, 1г, 1д, 1е-д заасан “яам”, “харъяа агентлаг” гэсэн мөрийг байгууллага тус бүрээр бөглөж, ЖҮХ-нд ирүүлнэ.

#### Маягт 1а

№	Төрийн захиргааны төв болон түүний харъяа агентлагийн нэр	Төрийн албан хаагчид /үндсэн/		
		Нийт	Үүнээс	
			эр	эм
1	Гадаад харилцааны яам	147	74	73
2	Агентлаг	-	-	-





**Маягт 1е**

№	Хороо, зөвлөл, комиссын нэр	Байгуулсан тушаал шийдвэр	Нийт бүрэлдэхүүний тоо	Дарга/ахлагч		Гишүүд	
				эр	эм	эр	эм
1	Гадаад харилцааны яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл	Гадаад харилцааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаал	15	1		8	6
2	Гадаад харилцааны яамны дэргэдэх Жендэрийн салбар зөвлөл	Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/76 дугаар тушаал	6	1		2	3
3	Гадаад харилцааны яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөл	ТАЗ-ийн 2019 оны 317 дугаар тогтоол	13	1		10	2
4	Гадаад харилцааны Сайдын зөвлөл	Гадаад харилцааны сайдын 2016 оны А/07 дугаар тушаал	17		1	11	5
5	Гадаад харилцааны яамны Ёс зүйн зөвлөл	Гадаад харилцааны сайдын 2022 оны А/16 дугаар тушаал	7	1		3	3

**Тайлбар:**

- Төрийн захиргааны төв байгууллага нь: 1/ "Салбарын сайдын ахалсан үндэсний болон салбарын хэмжээний хороо, зөвлөл, комисс", 2/ "Төрийн нарийн бичгийн даргын ахалсан хороо, зөвлөл, комисс", 3/ "Харъяа агентлагийн дарга нарын ахалсан хороо, зөвлөл, комисс" гэсэн мөрөн дэх мэдээллийг байгууллага тус бүрээр гаргаж, нэгтгэхгүйгээр тайлагнана.

- Төрийн захиргааны төв байгууллагын харъяа агентлаг нь: "Агентлагийн даргын ахалсан хороо, зөвлөл, комисс" гэсэн мөрөнд тухайн агентлагийн дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүний хүйсийн мэдээллийг гаргаж, яаманд тайлагнана. Энэ мэдээнд орон нутаг дахь босоо удирдлагатай байгууллагуудын дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүний хүйсийн судалгааг оруулахгүй.

Хавсралт 4

Жендэрийн тэгш байдлыг хангах талаар салбарт баримтлах бодлогыг хэрэгжүүлэх  
Жендэрийн салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөө, төсөв

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Санхүүжлтийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин/ 2021-12-31	Зорилтот түвшин 2023-12-31	Хариуцах албан тушаалтан
<p><b>Бодлогын баримт бичгийн нэр, баталсан шийдвэрийн дугаар, огноо:</b> Гадаад харилцааны сайдын 2020.10.13-ны 07/41 дүгээр тушаалаар баталсан Гадаад харилцааны салбарт Жендэрийн талаар баримтлах бодлого.</p> <p><b>Бодлогын зорилго 1.</b> Гадаад харилцааны яамны бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтэд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх замаар байгууллагын бүх түвшинд жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөх, түүнийг хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэхэд оршино.</p> <p><b>Бодлогын зорилт 1:</b> Дипломат албанд жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүйн орчин, бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох</p> <p><b>Үйл ажиллагааны чиглэл 1:</b> Дипломат албаны үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэгтгэх мэдлэг ойлгоц, чадавхыг бүрдүүлэх.</p> <p><b>Үр дүн:</b> Дипломат албаны жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.</p>							
1.2	Жендэрийн талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх, жендэрийн мэдрэмжтэй сургалт зохион байгуулах	Тухайн жилийн батлагдсан төсөв	Улсын төсөв	Сургалтын тоо Оролцох хүний тоо	Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/34	1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай болон Салбар дундын	ГХЯ

					дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, цар тахлын нөхцөл байдлын үед албан хаагчдын эрүүл мэнд, гэр-ажлын тэнцвэрт байдлыг хангаж, шаардлагатай тохиолдолд цахимаар ажиллуулах арга хэмжээг авч ажиллав.	стратеги төлөвлөгөөний талаар 2 сургалт зохион байгуулах 2.Сургалтад 100-аас дээш хүмүүс оролцуулах	
1.3	Салбарын жендэрийн тэгш байдлыг хангах хүрээнд жендэрийн асуудлаар санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих хариуцлагын тогтолцоог бий болгох	Тухайн жилийн батлагдсан төсөв	Улсын төсөв	Хүлээн авсан санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	Ес зүйн зөвлөлд хөндлөнгийн хяналтын тогтолцоо бүрдүүлсэн	100 хувь шийдвэрлэсэн байх	ГХЯ

**Зорилт 2.** Гадаад харилцааны яам, Дипломат төлөөлөгчдийн газруудын нийт ажилтны жендэрийн тэгш байдлыг талаарх мэдлэг, чадавхийг сайжруулах

**Үр дүн:** Гадаад харилцааны яам, Дипломат төлөөлөгчдийн газруудын ажилтнуудын 50-иас дээш хувь нь жендэрийн шаталсан сургалтад хамрагдаж, ажлын гүйцэтгэлийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах мэдлэг, чадвартай болсон байна.

2.1	Дипломат албаны нийт удирдах албан тушаалтны жендэрийн тэгш байдлыг хангах үйл явцыг манлайлах чадавхийг сайжруулах	Тухайн жилийн батлагдсан төсөв	Улсын төсөв	Хамрагдсан сургалтын тоо	Тус яамны жендэрийн асуудал хариуцсан ажилтан ЖҮХ-ноос зохион байгуулсан сургалтад хамрагдсан.	ГХЯ-ны болон ДТГ-ын удирдах албан тушаалтан нарыг Төрийн албаны зөвлөлийн жендэрийн цахим сургалтад хамруулсан байх	ГХЯ
2.2	Гадаад харилцааны яамны нийт албан хаагчдад жендэрийн мэдлэг, ойлголтын талаар шаталсан сургалт зохион байгуулах	Тухайн жилийн батлагдсан төсөв	Улсын төсөв	Хамрагдсан албан хаагчдын тоо Зохион байгуулсан сургалтын тоо	Жендэрийн үндэсний хорооны 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)”-г ГХЯ-ны албан хаагчдад танилцуулах арга хэмжээ 2022.11.16-ны өдөр болов.	ГХЯ-ны албан хаагчид жендэрийн талаар мэдлэг, ойлголттой болсон байх	ГХЯ
2.3	ДТГ-т ажиллаж буй албан хаагчдын эрүүл мэндийн нэгдсэн стандарт, даатгалд хамруулах	Тухайн жилийн батлагдсан төсөв	Улсын төсөв	150	ДТГ-т ажиллаж буй албан хаагчдыг эрүүл мэндийн даатгалд 11 тэрбум төгрөг төсөвлөсөн	Эрүүл мэндийн хүртээмжтэй үйлчилгээ авах боломжийг	ГХЯ

					бөгөөд МУ-аас хилийн чанадад суугаа ДТГ-ууд хамрагдсан.	бүрдүүлсэн байх	
2.4	“Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх салбарын дундын зохицуулалтын сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Тухайн жилийн батлагдсан төсөв	Улсын төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж, хүргүүлсэн байх	“Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг гаргаж, ЖҮХ-нд хүргүүлсэн	ГХЯ болон хилийн чанадад суугаа ДТГ-уудад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүүг багасгах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 11 заалтын хэрэгжилтийг гаргаж, ЖҮХ-нд хүргүүлсэн байх	ГХЯ

**Зорилт 3.** Салбарын ажилтан, албан хаагчдын ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрт байдлыг сайжруулж, ажиллах орчныг жендэрийн мэдрэмжтэй болгох

**Үр дүн:** Ажилтнуудын ялгаатай байдал, онцлог хэрэгцээнд нийцүүлэн ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан байна.

3.1	Ажлын орчин нөхцөл, хангамжийг албан хаагчдын ялгаатай байдал, онцлон	Тухайн жилийн батлагдсан төсөв	Улсын төсөв	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан хүний тоо	ДТГ-т ажиллаж буй албан хаагчдыг эрүүл мэндийн даатгалд 11 тэрбум төгрөг төсөвлөсөн	Зарим ДТГ-уудыг Олон улсын жишиг даатгалын системд	ГХЯ
-----	---	--------------------------------	-------------	---	---	--	-----

	хэрэгцээнд өөрчилж, хүрээнд ажиллаж эрүүл нэгдсэн болгох	нийцүүлэн сайжруулах ДТГ-уудад буй ажилтнуудын даатгалыг стандарттай болгох				бөгөөд хилийн суугаа хамрагдсан.	МУ-аас чанадад ДТГ-ууд хамруулсан байх	
3.2	Ялгаатай ялгаварлан дарамт тэвчих байгууллагын хөгжүүлэх	байдал, гадуурхалт, хүчирхийллийг тогтолцоо, соёлыг	Тухайн жилийн батлагдсан төсөв	Улсын төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2022.11.25-12.10-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны танилцуулах хуудас, холбогдох мэдээллийг ГХЯ-ны мэдээллийн самбар, КХ-ийн иргэдэд үйлчлэх танхимд байршуулж, "Цагаан туузтаны хөдөлгөөн"-д нэгдэв.	2 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байх	ГХЯ
3.3	Жендэрт хүчирхийлэлтэй салбар зохицуулалт,	суурилсан тэмцэхэд дундын хамтын	Тухайн жилийн батлагдсан төсөв	Улсын төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2022.11.25-12.10-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн Жендэрт суурилсан	ГХЯ болон хилийн чанадад суугаа ДТГ-уудад жендэрт	ГХЯ

	ажиллагааг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх				хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны танилцуулах хуудас, холбогдох мэдээллийг ГХЯ-ны мэдээллийн самбар, КХ-ийн иргэдэд үйлчлэх танхимд байршуулж, "Цагаан туузтаны хөдөлгөөн"-д нэгдэв.	суурилсан хүчирхийлэлтэ й тэмцэх чиглэлээр тодорхой арга хэмжээг зохион байгуулсан байх	
--	--	--	--	--	---	---	--

**Салбарын жендэрийн бодлогын 1 зорилго, 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөсөн.**

**Тайлбар:**

Холбогдох мэдээллийг Төсвийн санал бэлтгэх ЖМТ-НМ-02 маягтаас авч болно.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГААС ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮНГИЙН 2022 ОНЫ МЭДЭЭ

А.Хаягийн хэсэг

Регистрийн дугаар: 1 0 3 4 5 1

Байгууллагын нэр: Гадаад харилцааны яам

Утасны дугаар: 7 0 0 8 2 2 2 2

Б.Үндсэн мэдээлэл

Үзүүлэлт	МД	Бүгд	Алхам
Жендэрийн талаар салбар баримтлах бодлоготой эсэх (Тийм-1, Үгүй-2)	1	1	
Жендэрийн салбар зөвлөл байгуулсан эсэх (Тийм-1, Үгүй-2)	2	1	2 → мөр(10)
Харьяа агентлаг, нэгжид жендэрийн дэд зөвлөлтэй эсэх (Тийм-1, Үгүй-2)	3	2	
Жендэрийн салбар зөвлөлийн гишүүдийн тоо мөр(4)=мөр(5+6)	4	5	
Эрэгтэй	5	2	
Эмэгтэй	6	3	
Салбар зөвлөлийн куралдааны тоо мөр(7)=мөр(8+9)	7	4	
Ээлжит	8	2	
Ээлжит бус	9	2	
Жендэрийн мэргэжлэтний тоо мөр(10)=мөр(11+12)	10	1	
Эрэгтэй	11	0	
Эмэгтэй	12	1	
Жендэрийн талаар салбар баримтлах бодлоготой эсэх (Тийм-1, Үгүй-2)	13	1	
Жендэрийн талаар сургалт зохион байгуулсан эсэх (Тийм-1, Үгүй-2)	14	1	2 → мөр(54)
Жендэрийн талаар зохион байгуулсан сургалтын тоо	15	1	
Сургалтад оролцогч байгууллага мөр(16)=мөр(17+18+19+20)	16	48	
Яам	17	1	
Агентлаг	18	47	
ТББ	19	0	
Бусад	20	0	
Сургалтад оролцогчдын нийт тоо мөр(21)=мөр(22+23)+мөр(30+35+42+48)	21	110	
Эрэгтэй	22	52	
Эмэгтэй	23	58	
Удирдах ажилтан мөр(24)=мөр(25+26)	24	12	
Эрэгтэй	25	4	
Эмэгтэй	26	8	
Хөгжлийн бэрхшээлтэй оролцогчдын тоо мөр(27)=мөр(28+29)	27	2	
Эрэгтэй	28	1	
Эмэгтэй	29	1	
Яамдаас сургалтад оролцогчдын тоо мөр(30)=мөр(31+32)	30	64	
Эрэгтэй	31	30	
Эмэгтэй	32	34	
Удирдах ажилтан мөр(33)=мөр(34+35)	33	12	
Эрэгтэй	34	4	
Эмэгтэй	35	8	
Агентлагаас сургалтад оролцогчдын тоо мөр(36)=мөр(37+38)	36	46	
Эрэгтэй	37	28	
Эмэгтэй	38	18	
Удирдах ажилтан мөр(39)=мөр(40+41)	39	0	
Эрэгтэй	40	0	
Эмэгтэй	41	0	
ТББ-аас сургалтад оролцогчдын тоо мөр(42)=мөр(43+44)	42	0	
Эрэгтэй	43	0	
Эмэгтэй	44	0	
Удирдах ажилтан мөр(45)=мөр(46+47)	45	0	
Эрэгтэй	46	0	
Эмэгтэй	47	0	
Бусад байгууллагаас сургалтад оролцогчдын тоо мөр(48)=мөр(49+50)	48	0	
Эрэгтэй	49	0	
Эмэгтэй	50	0	
Удирдах ажилтан мөр(51)=мөр(52+53)	51	0	
Эрэгтэй	52	0	
Эмэгтэй	53	0	
Тур, тусгай арга хэмжээ бүхий бодлого, хөтөлбөр, шийдвэрийн тоо	54	2	
Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгасан	55	1	
Байгууллагын бодлого шийдвэрт нөлөөлөхүйц Хороо, Зөвлөл, Комиссын бүрэлдэхүүний гишүүний нийт тоо мөр(56)=мөр(57+58)	56	16	
Эрэгтэй	57	11	
Эмэгтэй	58	5	
Жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд байгууллагын төлөвлөсөн төсөв, мян.төг	59	0	
Зарцуулсан төсөв, мян.төг	60	0	
Байгууллагын албан хаагчдын нийт тоо мөр(61)=мөр(62+63)	61	147	
Эрэгтэй	62	74	
Эмэгтэй	63	73	

Тайлан хянасан: ТЗУГ-ын захирал С.Золжаргал  
/Албан тушаал/ /Нэр/

Тайлан гаргаж нэгтгэсэн: ТЗУГ-ын зөвлөх Г.Сувдсүрэн  
/Албан тушаал/ /Нэр/

2023 оны 1 дүгээр сарын 09 өдөр

  
/Гарын үсэг/

  
/Гарын үсэг/

**2020.07.01-НЫ МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН 99 ДҮГЭЭР ЗАХИРАМЖААР БАТЛАГДСАН ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ДУНДАЖ НАСЛАЛТЫН ЗӨРҮҮГ БАГАСГАХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ (2020-2022) ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТ**

**Зорилго:** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)-г жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үнэлэх, дүгнэх

Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх хугацаа: 2023 оны 1 дүгээр сарын 20-ны

Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт		Зорилтот түвшин 2022 он	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл, хувь	Хэрэгжилтийг хариуцсан байгууллага	Хамтран хэрэгжүүлсэн байгууллага	Дэлгэрэнгүй тайлбар (Хэрэгжээгүй шалтгаан)
			Он	Түвшин						
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
<b>Нийтлэг хэрэгжүүлэх ажил нь /Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас төрийн болон хувийн хэвшлийн бүх шатны байгууллагууд хэрэгжүүлэх боломжтой ажлуудыг хэлж байгаа болно/</b>										
<b>Зорилт 1. Эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах</b>										
1) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд “Байгууллагын эрүүл мэндийн үзлэг”-ийг хөдөлмөрийн дотоод журамд тусгах замаар эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулах (ЭЭХДНЗБТАХАХТ 1.2)	Журамд нэмэлт өөрчлөлт оруулах	-Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах тухай заалтыг хөдөлмөрийн дотоод журамд тусгасан байгууллагын тоо -Эрүүл мэндийн урдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эрэгтэй албан хаагчдын мэдээлэл	2019	0	Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр санал боловсруулах аар бэлтгэл ажлыг хангаж байх	-ТНБД-ын 2021.12.17-ны өдрийн А-190 тушаалаар “Сөүл Сэннорс Товер” ХХК /Сонгдо эмнэлэг/-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, яамны 60 албан хаагчийг 2022.1-2 дугаар сард эрүүл мэндийн багц шинжилгээнд хамруулсан. 2022.11.03-ны өдөр яам болон ДБУЭГ-ын нийт 95 ажилтан, албан хаагчдыг томуугийн вакцинд үнэ төлбөргүйгээр хамруулсан. Үүнээс 50 эрэгтэй албан хаагчид вакцинд хамрагдсан. -Мөн МУ-аас хилийн чанадад суугаа ДТГ-ууд дотоод журамдаа албан хаагчид болон тэдний гэр бүлийн гишүүдийг эрүүл мэндийг үзлэгт жил бүр хамруулж байхаар тусгасан бөгөөд суугаа орны болон олон улсын эрүүл мэндийн “PING AN INSURANCE”, “BUPA GLOBAL”, “CARPS INTERNATIONAL”, “ÖGK” зэрэг даатгалын компаниудтай гэрээ байгуулж, албан хаагчдыг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж байна.	100%	ГХЯ болон ДТГ-ууд	Холбогдох эрүүл мэндийн даатгалын компани	

Хэрэгжилт: Яам, ДТГ-т ажиллаж буй албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулдаг.

**Зорилт 2. Зам, тээврийн шалтгаант ослоос урьдчилан сэргийлэх замаар эрэгтэйчүүдийн осол, гэмтэл, нас баралтыг бууруулах**

<p>2) Интернэт орчинд эрэгтэйчүүдийн сонирхол, нас, амьдарч буй газар оронд тохирсон контентын шинэ хэлбэрийг ашиглан зам тээврийн осол, аваар, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээллийг түгээх (ЭЭХДНЗБ ТАХАХТ 2.4)</p>	<p>Монгол эрэгтэйчүүдийн дунд нас баралт өндөр байгаа учир түүнээс урьдчилан сэргийлэх<sup>р</sup> зорилгоор яам болон ДТГ-ын хүрээнд зохион байгуулсан тодорхой ажил</p>	<p>-Нийгмийн сүлжээний сувгуудаар дамжуулан зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан, үзэлт хандалтын тоо</p>	<p>2019</p>	<p>0</p>	<p>100,000</p>	<p>МУ-аас хилийн чанадад суугаа ДТГ-т томилогдсон жолооч нарт ГХЯ болон ДТГ-ын чиг үүрэг, ДТГ-т ажиллах үүрэг хариуцлагын талаар үе шаттай сургалт зохион байгуулдаг. Мөн хилийн чанадад суугаа ДТГ-ууд нь жолоо барьдаг эрэгтэй ажилтнуудад whatsapp, viber, вичат, фб зэрэг олон нийтийн сүлжээгээр дамжуулан осол, аваараас урьдчилан сэргийлэх мэдээллийг түгээдэг. Түүнчлэн суугаа оронд болсон байгалийн гамшиг, тухайлбал, хар шуурга, агаарын хэт халалт болон эрс хүйтрэлийн үеэр нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд мэдээлэл, сэрэмжлүүлэг түгээдэг байна. Европын орнуудад суугаа ДТГ-ууд нь иргэдийн цуглаан, үймээн самуунтай улс орнуудад машинаар зорчихгүй байх анхааруулгыг байнга өгч байна.</p>	<p>100%</p>	<p>ГХЯ болон ДТГ-ууд</p>		
--	---	---	-------------	----------	----------------	--	-------------	--------------------------	--	--

Хэрэгжилт: ГХЯ болон ДТГ-уудын тээврийн хэрэгслүүдийг жил бүр техникийн үзлэг, оношилгоонд хамруулдаг. Бүрэн бус техникээр ажил үүрэг гүйцэтгэхгүй байх нөхцөлийг ханган ажилладаг.

**Зорилт 3. Хөвгүүд, эрэгтэйчүүдийн эрүүл зөв аж төрөх мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах замаар чанартай, урт наслалтыг дэмжих**

<p>3) Эрэгтэйчүүдийн физиологи, бие бялдрын хувьд эрүүл, илүүдэл жингүй байх уриалга, арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулах (ЭЭХДНЗБТАХАХТ 3.3)</p>		<p>Зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан</p>	<p>2019</p>	<p>-</p>	<p>Спортынарга хэмжээг байнга зохион байгуулж байх</p>	<p>ГХЯ-ны зүгээс албан хаагчдын эрүүл мэнд, бие бялдар, илүүдэл жингүй байх зорилгоор 7 хоногийн 1, 3, 5 дахь өдрүүдэд мэргэжлийн багштай ангид тус яамны 10 гаруй эрэгтэй албан хаагч хичээллэж байна. Хилийн чанадад суугаа ДТГ-ууд албан хаагчдын дунд сагсан бөмбөг, ширээний теннис, гар бөмбөг, усан сэлэлт, явган аялал, ууланд авирах зэрэг спортын арга хэмжээг байнга зохион байгуулж, зарим ажилтныг иога, усан сэлэлтийн сургалтанд хамруулав. Зарим ДТГ-ууд өглөө, оройд цэцэрлэгт хүрээлэнд алхалт хийх уриалга гаргаж хэвшсэн ба ДТГ-уудад ажиллаж буй нийт эрэгтэйчүүдийн 80 хувь нь фитнесээр хичээллэж байна.</p>	<p>100%</p>	<p>ГХЯ болон ДТГ-ууд</p>		
---	--	---	-------------	----------	--	---	-------------	--------------------------	--	--

						Тухайлбал, "Chinggis Khan Cup" гольфын нөхөрсөг тэмцээн, Сагсан бөмбөгийн Хойд Америкийн аварга шалгаруулах тэмцээн, хөл бөмбөг, боулинг, жиүжүцү зэрэг спортын тэмцээнүүдийг зохион байгуулснаас гадна суугаа оронд суралцаж байгаа Монгол оюутнуудтай хамтран сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулав.				
<b>Хэрэгжилт:</b> Эрэгтэйчүүдийн физиологи, бие бялдрын хувьд эрүүл, илүүдэл жингүй байх уриалга, арга хэмжээний хүрээнд эрэгтэй албан хаагчдын дунд спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна.										
4) Эрэгтэйчүүдийн сонирхлоороо нэгдэж буй клуб, спортын төрлөөр дамжуулан стресс тайлах, сэтгэлзүйн зөвлөгөөг түгээх, зөв үлгэр дууриалал үзүүлж буй бүлэг, клубыг дэмжих, сурталчлах (ЭЭХДНЗБТАХАХТ 3.5)		-Клуб, спортын холбоотой хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан -Клуб, спортын холбоодын тухай нэгдсэн мэдээллийн сан, статистик бий болгох	2019	0	1	ГХЯ-ны эрэгтэй албан хаагчид 7 хоногт 2-3 удаа сагсан бөмбөг тоглох, мөн иогагаар хичээллэж байна. Хилийн чанадад суугаа ДТГ-уудад эрэгтэй албан хаагчдыг суугаа орны холбогдох байгууллагаас зохион байгуулдаг гүйлт, хөлбөмбөг, сагс, дугуйн клуб, гольфийн клубын дугуйлан болон тэмцээн уралдаанд тогтмол оролцуулж байна. Түүнчлэн зарим ДТГ-уудад монголын уламжлалт шагайн харваа болон сагсан бөмбөг, гольфийн салбар холбоог ажиллуулж байна. Мөн эрүүл мэндийн даатгалын багцдаа стресс тайлах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг багтаасан байна.	100%	ГХЯ болон ДТГ-ууд		
<b>Хэрэгжилт:</b> Эрэгтэйчүүдийн дунд стресс тайлах, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх чиглэлд анхаарал хандуулж, эрүүл мэндийн даатгалын багцад дээрх үйлчилгээг багтаав.										
5) 0-18 нас хүртэлх хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагч нарт чиглэсэн эрэгтэй, эмэгтэй хүүхдийн эрүүл өсөж, бойжих эрхийг хангах, талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, зорилтот арга хэмжээ зохион байгуулах, гэр бүлийн боловсрол олгох сургалтын агуулгад тусгах (ЭЭХДНЗБТАХАХТ 3.7)		-Эцэг, эх асран хамгаалагч нарт хандсан уриалга, зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан -Гэр бүлийн боловсрол олгох сургалтын агуулгад тусгагдсан байдал	2019	-	-	ГХЯ-ны албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд 2016 оноос тус яамны дэргэд 75 хүүхдийн багтаамжтай цэцэрлэгийг ажиллуулж байна. Хилийн чанадад суугаа зарим ДТГ-ууд албан хаагчдын 0-18 насны хүүхдүүдийн эрүүл мэндийг хамгаалахад анхаарал хандуулж, эрүүл мэндийн даатгалд хамруулснаар эмнэлгийн шуурхай тусламж авдаг болсон. Мөн 0-18 насны хүүхдүүдэд байгаль эх дэлхийгээ хамгаалах, танин мэдэхүй болон хүүхдийн хүмүүжил, ёс суртахууны талаар эцэг, эхчүүдийг оролцуулсан сургалтыг байнга зохион байгуулдаг. Тухайлбал, зарим ДТГ-уудын	100%	ГХЯ болон ДТГ-ууд		

					<p>Эмэгтэйчүүдийн клубээс 7 хоногт 2-3 удаа сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд монгол хэлний хичээл заадгаас гадна хүүхдүүдэд үлгэр ярих, хүүхдийн хүмүүжил, танин мэдэхүйн сэдвүүдээр сургалт зохион байгуулдаг.</p> <p>Мөн Монгол сургуулиудын үйл ажиллагааг тогтмол дэмжиж, хамтран үйл ажиллагаанууд зохион байгуулсны зэрэгцээ Соробан сампингийн сургалт, Spelling Bee үсэглэлийн тэмцээн, Хүүхдийн Пан Америкийн аварга шалгаруулах тэмцээн, "Би Монгол хүн" танин мэдэхүйн тэмцээнийг тус тус 0-18 насны хүүхдүүдийн дунд зохион байгуулсан байна.</p> <p>Монгол соёл-Монгол дархлаа" санаачилгын хүрээнд суугаа орон дахь хэл соёлын төвүүдтэй ажлын шаардлагаар удаа дараа уулзалт хийж, Монголын түүх, соёлыг сурталчлан танилцуулах зорилго бүхий видео бүтээлүүдийг суугаа орны хэл, соёлын төвүүдэд танилцуулснаар тухайн орны Монгол хэл, соёлын сургалтын төвүүд хичээлдээ тогтмол ашиглаж байна.</p>					
<p><b>Хэрэгжилт:</b> ГХЯ болон хилийн чанадад суугаа ДТГ-ууд нь 0-18 нас хүртэлх хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагч нарт чиглэсэн эрэгтэй, эмэгтэй хүүхдийн эрүүл өсөж, бойжих эрхийг хангах, талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлд анхаарал хандуулан ажиллаж, тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулав.</p>										
<p>6) 0-12 насны хүүхэдтэй эцэг, өрх толгойлсон эрэгтэйчүүдэд зориулан гэр бүлдээ зарцуулах цагийг уртасгах боломжийг бүрдүүлэх, гарсан сайн туршлагыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх (ЭЭХДНЗБТАХАХТ 3.8)</p>		<p>-0-12 насны хүүхэдтэй эцэг, өрх толгойлсон эрэгтэйчүүдийн ажлын цагт уян хатан бодлого хэрэгжүүлсэн байгууллагын тоо</p>	2019	0		<p>ГХЯ болон ДТГ-уудад 0-12 насны хүүхэдтэй албан хаагчдын ажиллах цагийн хуваарийн хөдөлмөрийн хуулийн дагуу мөрдөн ажиллаж байна. Мөн зарим ДТГ-ууд бага насны хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулах, суугаа орны баяр ёслолын тэмдэглэлт өдрүүдэд эцэг, эхчүүдэд чөлөө олгох, спортын арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр ажиллаж байна. Тухайлбал, ЭСЯ-наас ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийг 2021-2022 онд өвлийн улиралд тэшүүрээр гулгах, зуны улиралд усан бассейнд явах эрхийн бичиг олгосон байна.</p>	100%	ГХЯ болон ДТГ-ууд		

**Хэрэгжилт:** Гэр бүл, үр хүүхэддээ гаргах цагийг нь ахиу байлгах үүднээс ажлын цагийг сунгахгүй байх, ажлын бус өдөр, ажлын бус цагаар ажиллуулахгүй байх бодлого барьж, хэрэгжүүлэв.

7) "Сэтгэцийн эрүүл мэнд-Аюулгүй ажлын байр", "Стрессгүй ажлын байр" зэрэг аян өрнүүлэх замаар стрессийг даван туулах, амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийн талаарх ойлголт, мэдлэг түгээх сургалт, зөвлөгөө өгөх (ЭЭХДНЗБТАХАХТ 3.9)		-Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр зохиосон үйл ажиллагааны тайлан	2019	-	-	ГХЯ болон ДТГ-ууд эрэгтэй ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор хамт олныг хамарсан уулзалтыг улирал тутам зохион байгуулж байна. Мөн ажлын байранд стрессгүй, харилцааны соёлтой, харилцааны эрүүл орчныг бүрдүүлэхэд ГХЯ болон ДТГ-ууд анхаарал хандуулан ажиллаж байна. ДТГ-уудад шинээр томилогдон ирсэн албан хаагчид сэтгэцийн эрүүл мэндийн үзлэгт орсны үндсэн дээр албан тушаалд томилогдож байгаа ба тэдний ажил, амьдралын ая тухтай орчныг бүрдүүлэхэд анхаарал хандуулж, ажлын байр, албан хаагчдын орон сууцанд их засвар хийж, тавилга, тоног төхөөрөмжийг шинэчилж байна. ДТГ-ууд нийт албан хаагч нартаа зориулж "Сэтгэцийн эрүүл мэнд-Аюулгүй ажлын байр", "Стрессгүй ажлын байр" зэрэг сургалтуудыг зохион байгуулав.	100%	ГХЯ болон ДТГ-ууд		
---	--	--	------	---	---	---	------	-------------------	--	--

**Хэрэгжилт:** "Сэтгэцийн эрүүл мэнд-Аюулгүй ажлын байр", "Стрессгүй ажлын байр" зэрэг аяны хүрээнд холбогдох сургалтуудыг зохион байгуулав.

**Зорилт 4. Үндэсний хэмжээнд хүйсээр ангилсан мэдээллийг өргөтгөн сайжруулах, хөвгүүд, эрэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээг анхаарсан хөгжлийн төлөвлөлтийг эхлүүлэх**

8) Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрыг хөгжүүлэх бодлогыг үндэсний түвшинд сурталчлах, хэрэгжилтийг хангасан аж ахуйн нэг байгууллагыг урамшуулах, сайн туршлагыг түгээх (ЭЭХДНЗБТАХАХТ 4.3)		Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрыг хэрэгжүүлсэн байгууллага, сайн туршлагын тоо	2019	-	-	ГХЯ болон хилийн чанадад суугаа ДТГ-ууд Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрыг хөгжүүлэх бодлогыг үндэсний түвшинд сурталчилж, хэрэгжилтийг хангаж ажиллав.	100%	ГХЯ болон ДТГ-ууд		
--	--	--	------	---	---	--	------	-------------------	--	--

**Хэрэгжилт:** ГХЯ болон хилийн чанадад суугаа ДТГ-ууд Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрыг хөгжүүлэх бодлогыг сурталчилж, хэрэгжилтийг хангаж ажиллав.

9) Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (ЭЭХДНЗБТАХАХТ 4.4)		Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд согтууруулах ундааны савалгаа, өндөр	2019	-	-	ГХЯ болон ДТГ-уудад архидан согтуурахтай тэмцэх асуудлыг байгууллагын дотоод журамд тусган хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Мөн суугаа оронд оршин суугаа иргэний нийгмийн төлөөллийг хүлээн авч уулзаж,	100%	ГХЯ болон ДТГ-ууд		
--	--	---	------	---	---	---	------	-------------------	--	--

		градуустай согтууруулах ундааны худалдаалах орчныг сайжруулах зохицуулалтыг нэмж тусгасан байна.				эрэгтэйчүүдийн оролцоог дэмжих чиглэлээр архины хамаарлаас зайлсхийх сургалтыг хамтран зохион байгууллахаар тохиролцсон байна. Мөн зарим ДТГ-ууд ЭСЯ-нд зохион байгуулах аливаа арга хэмжээнд согтууруулах ундаа хэрэглэхгүй байхаар байгууллагын дотоод журамдаа тусгасан байна.				
<b>Хэрэгжилт:</b> ГХЯ болон ДТГ-уудад архидан согтуурахтай тэмцэх асуудлыг байгууллагын дотоод журамд тусган хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.										
10) Эрэгтэйчүүдийн оролцоог дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллага, Төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж үйл ажиллагааг дэмжих, олон нийтэд таниулах, олон улсын байгууллагын дэмжлэгээр чадавхжуулах (ЭЭХДНЗБТАХАХТ 4.5)		-Эрэгтэйчүүдийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан; Хөвгүүд, эрэгтэйчүүдийг хамруулсан үйл ажиллагааны тоо	2019	-	-	Энэ ажлын хүрээнд Монгол Улсаас хилийн чанадад суугаа ДТГ-ууд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, 2021 онд Нүүдэлчин гарал үүсэлтэй ард түмнүүдийн Хуралдай наадамд монголын шагайн харвааны 10 багийн 80 гаруй харваачид, 2022 онд Үндэсний их баяр наадмаар шагайн харваан тэмцээнд 6 багийн 40 гаруй эрэгтэй оролцсон байна. Мөн Олон улсын Аавуудын өдөрт зориулан Хагас марафоны тэмцээн зохион байгуулав.	100%	ГХЯ болон ДТГ-ууд		
<b>Хэрэгжилт:</b> ГХЯ болон ДТГ-ууд эрэгтэйчүүдийн оролцоог дэмжих чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.										
11) Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх (ЭЭХДНЗБТАХАХТ 4.6)		-Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн биелэлт	2019	-	-	Үндэсний хөтөлбөрт суурилсан яамны хэмжээний хөтөлбөрийг боловсруулах чиглэлээр судалж байна.	70%	ГХЯ болон ДТГ-ууд		
<b>Хэрэгжилт:</b>										

2023 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр

ТАЙЛАН ГАРГАСАН АЛБАН ТУШААЛТНЫ  
Нэр албан тушаал, гарын үсэг, тамга

ХЯНАЖ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
Дотоод аудитын үнэлгээ баталгаажуулалт хийсэн  
албан тушаалтны нэр албан тушаал, гарын үсэг, тамга



ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ТӨРИЙН  
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЗӨВЛӨХ  
Г.СУВДСҮРЭН

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ТӨРИЙН  
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
С.ЗОЛЖАРГАЛ